

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мөрөн сум 2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 цахим хаяг: tegshdelqerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Дддд.дд.дд № 01/195
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Б.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,251.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой 566.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь тайланд онд Ахмад сангийн данс нээж байгууллагын төсвөөс 8,017.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>165,964,517.19</u>	<u>162,221,497.09</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	8,017,520.35
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	8,017,520.35
3121	Төгрөг	-	8,017,520.35
31211	Төрийн сангийн харилцах	-	8,017,520.35
33	АВЛАГА	-	137,130.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	137,130.14
35	БАРАА МАТЕРИАЛ	165,964,517.19	154,066,846.60
351	Түүхий эд материал	39,509,413.00	38,511,458.00
35110	Тусгай зориулалттай материал	37,397,866.00	37,397,866.00
35130	Эм боох материал	2,111,547.00	1,113,592.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,006,180.42	6,435,635.82
354	Хангамжийн материал	58,603,923.77	52,664,752.78
35410	Бичиг хэргийн материал	65,000.00	65,000.00
35420	Аж ахуйн материал	24,086,381.77	24,516,481.77
35440	Түлш, шатах тослох материал	1,263,229.00	1,875,910.00
35450	Барилгын засварын материал	2,799,118.00	3,089,818.00
35460	Хүнсний материал	28,883,200.00	21,496,548.00
35470	Бусад хангамжийн материал	1,506,995.00	1,620,995.01
35600	Мал амьтад	60,845,000.00	56,455,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,209,193,131.59</u>	<u>1,162,684,308.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,209,193,131.59	1,162,684,308.92
391	Газар		
392	Биет хөрөнгө	876,797,762.26	830,419,708.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,046,863,362.52	1,046,863,362.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	(277,000,090.82)	(323,854,640.54)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,118,000.00	153,118,000.00

39204	Хуримтлагдсан элэгдэл	(113,615,999.87)	(122,287,082.81)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,958,513.60	147,175,648.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(103,677,754.95)	(114,826,354.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,533,154.38	30,633,576.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,244,520.46)	(22,243,898.66)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	8,245,098.00	8,245,098.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,912,500.00	36,601,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,294,500.14)	(9,005,000.18)
393	Биет бус хөрөнгө	332,395,369.33	332,264,600.00
39301	Програм хангамж	6,417,692.31	6,417,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,286,922.98)	(6,417,692.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	332,264,600.00	332,264,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,375,157,648.78</u>	<u>1,324,905,806.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>-</u>	<u>566,136.82</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	566,136.82
413	Өглөг	-	566,136.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	566,136.82
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,374,855,148.78</u>	<u>1,324,339,669.19</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,374,855,148.78	1,324,339,669.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	330,587,765.90	330,587,765.90
51101	Өмч: - төрийн	330,587,765.90	330,587,765.90
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
512	Хуримтлагдсан үр дүн	909,936,554.50	859,118,574.91
51210	Өмнөх үеийн үр дүн	884,103,226.28	909,936,554.50
51220	Тайлант үеийн үр дүн	25,833,328.22	(50,817,979.59)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	134,633,328.38	134,633,328.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,375,157,648.78</u>	<u>1,324,905,806.01</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	799,358,955.00	766,863,417.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,934,155.00	56,471,417.01
120	Нийтлэг татварын бус орлого	69,934,155.00	56,471,417.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,934,155.00	56,471,417.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,957,000.00	11,022,250.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	58,977,155.00	45,449,167.01
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	729,424,800.00	710,392,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	727,619,000.00	710,392,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	727,619,000.00	710,392,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,805,800.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	505,800.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	768,724,126.78	817,681,396.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	768,724,126.78	817,681,396.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	745,287,782.38	801,883,453.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,574,780.67	568,137,136.33
210101	Үндсэн цалин	376,163,888.64	383,800,596.67
210102	Нэмэгдэл	185,913,557.79	175,177,657.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,300.00	
210104	Урамшуулал	1,328,774.82	9,158,882.30
210105	Гэрээт ажлын хөлс	8,259.42	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,809,615.13	10,318,996.59
210201	Тэтгэврийн даатгал	55,635.59	756,418.98
210202	Тэтгэмжийн даатгал	5,236.29	72,378.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,545.36	82,072.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,309.07	16,414.57

210205	Эрүүл мэндийн даатгал	9,740,888.82	9,391,711.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,592,555.60	62,913,200.00
210301	Гэрэл, цахилгаан	12,491,754.10	12,036,062.11
210302	Түлш, халаалт	47,925,700.00	48,368,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,175,101.50	2,508,537.89
2104	Хангамж, бараа материалын зардал	24,253,833.20	22,782,619.00
210401	Бичиг хэрэг	1,911,600.00	2,627,900.00
210402	Тээвэр, шатахуун	9,856,101.00	11,237,919.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,110,700.20	3,176,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,290,932.00	680,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,309,500.00	
210408	Бараа материал акалсны зардал	1,775,000.00	5,060,000.00
2105	Нормативт зардал	39,047,985.96	54,072,106.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,955,216.96	2,003,875.00
210502	Хоол, хүнс	36,092,769.00	50,556,852.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,511,379.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,433,504.00	5,718,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	288,904.00	2,176,900.00
210604	Урсгал засвар	3,144,600.00	3,542,000.00
2107	Томилолт, зочны зардал	494,000.00	445,700.00
210702	Дотоод албан томилолт	494,000.00	445,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,108,500.00	2,995,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	315,800.00	1,081,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	610,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	371,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	185,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	942,000.00	898,500.00
210807	Газрын төлбөр	492,700.00	458,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,973,007.82	74,498,954.67

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	777,800.00	664,875.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	418,168.00	319,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,777,039.82	73,514,879.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,436,344.40	15,797,943.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	302,400.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	302,400.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,645,000.00	2,180,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,645,000.00	2,180,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,983,144.40	13,617,943.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,983,144.40	13,617,943.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	505,800.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	505,800.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>30,634,828.22</u>	<u>(50,817,979.59)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,801,500.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,801,500.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,801,500.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>25,833,328.22</u>	<u>(50,817,979.59)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>740,381,800.00</u>	<u>731,591,770.35</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,957,000.00	21,199,770.35
120	Нийтлэг татварын бус орлого	10,957,000.00	21,199,770.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,957,000.00	13,182,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,957,000.00	13,182,250.00
120009	Бусад орлого	-	8,017,520.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	729,424,800.00	710,392,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	727,619,000.00	710,392,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	727,619,000.00	710,392,000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,805,800.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	505,800.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	738,005,800.00	723,574,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	738,005,800.00	723,574,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	715,794,455.60	709,536,306.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	563,808,700.21	575,725,650.00
210101	Үндсэн цалин	374,354,400.00	384,464,249.66
210102	Нэмэгдэл	186,337,179.54	184,758,487.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,404,000.00	1,404,000.00
210104	Урамшуулал	1,713,120.67	5,098,912.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,415,395.59	10,318,996.59
210205	Эрүүл мэндийн даатгал	9,415,395.59	10,318,996.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,592,555.60	62,913,200.00
210301	Гэрэл, цахилгаан	12,491,754.10	11,806,000.00
210302	Түлш, халаалт	47,925,700.00	48,368,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,175,101.50	2,738,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,300,100.20	18,335,300.00
210401	Бичиг хэрэг	1,820,000.00	2,627,900.00
210402	Тээвэр, шатахуун	10,480,600.00	11,850,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,151,700.20	3,176,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	847,800.00	680,500.00
2105	Нормативт зардал	37,496,300.00	31,588,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,989,700.00	693,420.00
210502	Хоол, хүнс	33,506,600.00	30,895,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,325,004.00	6,009,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,525,404.00	2,538,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	170,000.00	138,700.00

210604	Урсгал засвар	3,629,600.00	3,332,100.00
2107	Томилолт, зочны зардал	494,000.00	445,700.00
210702	Дотоод албан томилолт	494,000.00	445,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,108,500.00	3,161,640.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	315,800.00	1,247,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	610,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.00	371,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	198,000.00	185,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	942,000.00	898,500.00
210807	Газрын төлбөр	492,700.00	458,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,253,900.00	1,037,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	777,800.00	643,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	476,100.00	394,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,211,344.40	14,037,943.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	302,400.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	302,400.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	420,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,983,144.40	13,617,943.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,983,144.40	13,617,943.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	505,800.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	505,800.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,376,000.00	8,017,520.35
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,376,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,376,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,376,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,376,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,376,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	8,017,520.35

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,017,520.35

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,587,765.90	135,471,176.66	883,265,378.00	1,349,324,320.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,587,765.90	135,471,176.66	883,265,378.00	1,349,324,320.56
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн			25,833,328.22	25,833,328.22
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,587,765.90	135,471,176.66	909,098,706.22	1,375,157,648.78
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,587,765.90	135,471,176.66	934,932,034.44	1,375,157,648.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,587,765.90	135,471,176.66	909,098,706.22	1,375,157,648.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			-50,817,979.59	-50,817,979.59
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,587,765.90	135,471,176.66	858,280,726.63	1,324,339,669.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	723,574,250.00	709,956,306.59	13,617,943.41	98%

21	УРСГАЛ ЗАРДАЛ	723,574,250.00	709,956,306.59	13,617,943.41	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	723,154,250.00	709,536,306.59	13,617,943.41	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	575,725,650.00	575,725,650.00	-	100%
210101	Үндсэн цалин	376,752,950.00	384,464,249.66	(7,711,299.66)	102%
210102	Нэмэгдэл	195,696,700.00	184,758,487.44	10,938,212.56	94%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,404,000.00	1,404,000.00	-	100%
210104	Урамшуулал	1,872,000.00	5,098,912.90	(3,226,912.90)	272%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,279,100.00	10,318,996.59	12,960,103.41	44%
210205	Эрүүл мэндийн даатгал	23,279,100.00	10,318,996.59	12,960,103.41	44%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,913,200.00	62,913,200.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	11,806,000.00	11,806,000.00	-	100%
210302	Түлш, халаалт	48,368,600.00	48,368,600.00	-	100%
210303	Цэвэр, бохир ус	2,738,600.00	2,738,600.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	18,335,300.00	18,335,300.00	-	100%
210401	Бичиг хэрэг	2,627,900.00	2,627,900.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	11,850,600.00	11,850,600.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,176,300.00	3,176,300.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	680,500.00	680,500.00	-	100%
2105	Нормативт зардал	31,588,700.00	31,588,620.00	80.00	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	693,500.00	693,420.00	80.00	100%
210502	Хоол, хүнс	30,895,200.00	30,895,200.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,009,700.00	6,009,600.00	100.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,538,800.00	2,538,800.00	-	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	138,700.00	138,700.00	-	100%
210604	Урсгал засвар	3,332,200.00	3,332,100.00	100.00	100%
2107	Томилолт, зочны зардал	445,700.00	445,700.00	-	100%
210702	Дотоод албан томилолт	445,700.00	445,700.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,819,300.00	3,161,640.00	657,660.00	83%

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,247,400.00	1,247,400.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	529,500.00	-	529,500.00	0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,300.00	371,420.00	90,880.00	80%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	185,800.00	185,800.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	901,600.00	898,500.00	3,100.00	100%
210807	Газрын төлбөр	492,700.00	458,520.00	34,180.00	93%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,037,600.00	1,037,600.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	643,100.00	643,100.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	394,500.00	394,500.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	420,000.00	420,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	420,000.00	420,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.00	420,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	723,574,250.00	737,192,193.41	(13,617,943.41)	102%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	710,392,000.00	724,009,943.41	(13,617,943.41)	102%
131001	Улсын төсвөөс санхүүжих	710,392,000.00	724,009,943.41	(13,617,943.41)	102%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,182,250.00	13,182,250.00	-	100%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,182,250.00	13,182,250.00	-	100%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,017,520.35		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа байхгүй.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь ШШГЕГ-ын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан “Цахимжуулалт, шинэ сэргэлт”-ийн жилийн ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. “Байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэн, хэрэгжилтийг хангах
3. Ногоон хөгжлийг дэмжих “100 сая мод” хөдөлгөөн өрнүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Цагдаа дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу Засаг даргын Тамгын газрын дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,251.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б			
Мөнгөн хөрөнгө	0.00	8,017.5	8,017.5
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	165,964.5	154,066.8	-11,897.7
Үндсэн хөрөнгө	1,209,193.1	1,162,684.3	-46,508.8
Нийт хөрөнгө	1,375,157.6	1,324,905.8	-50,251.8
Өр төлбөр	0.0	566.1	566.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,375,157.6	1,324,339.7	-50,817.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,375,157.6	1,324,905.8	-50,251.8

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 8,017.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой 566.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байна. Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 719,985.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 10,700.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 712,885.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх дүнг 10,700.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 710,392.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, туслах үйл ажиллагааны орлогоос 13,182.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 13,617.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 709,956.3 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний зардлын төсвийг 13,617.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/						
д/д	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /70705/	Үндсэн үйл ажиллагаа /80101/	702,491.4	688,873.6	13,617.8	98%
2		Туслах үйл ажиллагааны зардал /80102/	13,182.2	13,182.2	0.0	100%
3		Холбооны суваг ашиглах /80220/	673.6	673.6	0.0	100%
4		Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ /80229/	6,807.0	6,806.9	0.1	99.9%
5		Нэг удаагийн тэтгэмж урамшуулал /80802/	420.0	420.0	0.0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр анхан шатанд хянаж, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 48/308 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 768,724.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,530.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох “шаардлагагүй” гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг алдаа зөрчилтэй илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторовын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цагдаагийн газрын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн хянаж үзлээ. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй нийт 352,047.8 мянган төгрөгийн 28 гүйлгээг мэдээлэхээс нийт 53,157.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд дараах зөрчил илэрсэн болно. Үүнд:

1. Ахмадын сангийн санхүүжилт болох 8,017.5 мянган төгрөгийг 2022 оны төсөвт тусгалгүйгээр бүрдүүлсэн, байгууллагын цэвэр, бохир усны зардлын ангиллаас цахилгааны төлбөрийн зардал болох 230.1 мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

2. Хувь хүнээс бараа, үйлчилгээ худалдан авсан төлбөр 369.4 мянган төгрөгийг төлөхдөө ХХОАТ-ын суутган төлөгчийн үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь "Хувь хүний албан татварын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагдаагийн газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2 зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	4,800.0	2	4,800.0	100
Нийт дүн	2	4,880.0	3	4,800.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,183.1 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, дахин давтахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 53,157.9 мянган төгрөгийн 1 зөрчил илрүүлж дахин давтахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цагдаагийн газрын 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүнтэй нийт 352,047.8 мянган төгрөгийн 28 гүйлгээг мэдээлэхээс нийт 53,157.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.
2. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн мэдээлж хэвших

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой 566.1 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, өр төлбөрийг барагдуулж ажиллах

3. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Ахмадын сангийн санхүүжилт болох 8,017.5 төгрөгийг 2022 оны төсөвт тусгалгүйгээр байгууллагын төсвөөс бүрдүүлсэн, байгууллагын цэвэр, бохир усны зардлын ангиллаас цахилгааны төлбөрийн зардал болох 230.1 төгрөгийг төлсөн байна.

Энэ нь "Төсвийн тухай хууль"-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын сангийн зардлыг төсөв тусгаж батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. Татварын суутган төлөгчийн үүрэгтэй холбоотой асуудал

Хувь хүнээс бараа, үйлчилгээ худалдан авсан төлбөр болох 369.4 мянган төгрөгийг төлөхдөө ХХОАТ-ын суутган төлөгчийн үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь "Хувь хүний албан татварын тухай хууль"-ийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх "Суутган төлөгч нь хувь хүнд орлого олгох бүрдээ түүний албан татвар төлөгчийн дугаар болон хувь хүн тус бүрээр олгосон орлого, түүнд ногдуулан суутгасан албан татварын хэмжээний мэдээллийг цахимаар, эсхүл хувь хүний орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, харьяа татварын албанд улирал тутам өссөн дүнгээр гаргаж илгээнэ" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын суутган төлөгчийн үүргийг биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөр барагдуулах	1	566.1					1	566.1				0
Төсвийн зарцуулалт	1	8,247.6					1	8,247.6				
Суутган төлөгчийн үүрэг	1	369.4					1	369.4				
Дүн	3	9,183.1					3	9,183.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн								
Мэдээлээгүй	3	53,157.9					1	53,157.9
Дүн	3	53,157.9	0	0	0	0	1	53,157.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Норм норматив баримтлаагүй								
Дүн								
Нийт дүн	3	53,157.9	0	0	0	0	1	53,157.9



БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР

АХЛАХ АУДИТОР

Б.ДАВААНЯМ

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Л.МАНДАХНАРАН